



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус газар 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбоотой, Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажлаа төлөвлөн, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хянан шалгах, хуримтлалын сангийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэх, хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах, тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгох, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад ил тод, шуурхай чирэгдэлгүй хүргэх, нийгмийн даатгалын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, тушаал, дүрэм, заавар, журам, аргачлалыг иргэдэд түгээн сурталчлах, тэдэнд тайлбарлан таниулах, зөвлөгөө өгөх, дэмжлэг тусалцаа үзүүлэх замаар даатгалын хамралтыг нэмэгдүүлж, ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах, мэргэшүүлэх сургалтанд хамруулахад чиглүүлж дараах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тушаал-16, дүрэм-1, даалгавар-63, зөвлөмж-20, 49-н чиглэлийг албан хаагчдад танилцуулан, цаг хугацаанд нь шийдвэрлэж, үүрэг даалгаврын биелэлтийг хүргүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал: 2024 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлд тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор “Маргаан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн батлагдсаны дагуу газрын дэргэдэх зөвлөлийн шинэчлэгдсэн бүрэлдэхүүнээр ажиллаж байна.

Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 65 дугаар тушаалын дагуу баталсан Аккруэл суурьт Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөртэй танилцан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/180 тоот “Хөрөнгийн тооллого явуулах тухай” тушаал, Хэлтсийн даргын тушаалын дагуу хэлтсийн үндсэн хөрөнгө болон бараа материалын жилийн эцсийн тооллогыг 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хийж гүйцэтгэлээ. Тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль боон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2008 оны 401 дүгээр тушаалаар баталсан “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого явуулах журам”-ыг баримтлан тооллогыг явууллаа. Тооллогод нийт 1 барилга, 2 газар, 171 тоног төхөөрөмж, 397 тавилга 1 машин зэрэг хөрөнгийг тоолсон.

Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/72 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилах журам” болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах Хэлтсийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. 2024 оны төсвийн төсөл, төсөөллийг боловсруулахдаа Нийгмийн даатгалын хамрах хүрээний үзүүлэлтүүд, нийгмийн даатгалын сангийн орлогын үзүүлэлтүүд, нийгмийн даатгалын сангийн зарлагын үзүүлэлтүүд зэргийг Нийгмийн даатгалын хууль,



тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Сангийн яам болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон шимтгэлийн хувь хэмжээ, зардлын норм, нормативууд, өмнөх 2 жилийн төсвийн гүйцэтгэл, тайлант хугацаанд батлагдсан төсөв, хүлээгдэж буй гүйцэтгэл, төсвийн төсөл, төсөөллийг боловсруулж байх хугацаанд бодлогын чиглэлээр баталсан хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөлд шаардагдах зардлын тооцоо зэргийг үндэслэн боловсруулж Нийслэлийн Нийгмийн Даатгалын Газарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын шинэчилсэн хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 72 ба 84 сараар 2019 оноос 2024 оны хооронд өндөр насны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр тогтоолгосон 3815 иргэний өргөдлийг хүлээн авч 60 сараар өөрчлөн тогтоож хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тэтгэврийн тусгай зохицуулалт буюу нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр/ нөхөр-ийн өндөр насны тэтгэврийн 20 хувиар нэмэгдүүлэх хуулийн дагуу 68 тэтгэвэр авагчдад тэтгэврийн өв олгосон байна.

Сайн дураар даатгуулагч малчны 5 хүртэл жилийн тэтгэврийн даатгалыг шимтгэлийг 50 хувийг төрөөс хариуцах хуулийн дагуу 87 даатгуулагчийн сайн дурын даатгалд хамруулсан. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах хуулийн дагуу 372 даатгуулагчийг хамруулсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/136 дугаар тушаалаар баталсан” Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил мэргэжлийн жишиг цалин”-ийн жагсаалтын дагуу анх тэтгэврээ тогтоолгохдоо цалингүй тогтоолгосон иргэдийн материалыг хүлээн авч өөрчлөн тогтоож олгож байна.

2024 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байгаа Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэг, 42 дугаар зүйлд тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны 362 дугаар тогтоолоор “Маргаан шийдвэрлэх зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн батлагдсаны дагуу газрын дэргэдэх зөвлөлийн шинэчлэгдсэн бүрэлдэхүүнээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт сэдвээр 2024.01.11, 2024.01.12-ны өдрүүдэд 3 удаагийн сургалтыг Амгалан Дулааны Цахилгаан Станц, Сtimo ХХК, E-Март худалдаа үйлчилгээний төвийн ажилтан албан хаагч нарт орлого шимтгэлийн байцаагч Б.Сарантуяа, Н.Сайнбаяр, Ж.Цэцэгсүрэн, тэтгэмжийн байцаагч М.Шинэжил, тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг нар ажиллаж, орлого шимтгэл, тэтгэвэр, тэтгэмжийн талаарх мэдээлэл зөвлөгөө өгч, даатгуулагчийн сонирхсон асуултанд хариулт өгч ажиллалсан. Сургалтанд нийт 445 ажилтан албан хаагч хамрагдлаа.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт сэдвээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Х.Булгантуяагийн ажлын албатай хамтран 2024.01.16-2024.01.23-ны өдрүүдэд 3 удаагийн сургалтыг СЭМҮТ, РИХА мед эмнэлэг, ПЕТРОСТАР группийн ажилтан, албан хаагч нарт орлого шимтгэлийн байцаагч Энэрэлт, Алтанцог, Цэцэгсүрэн, тэтгэмжийн байцаагч М.Шинэжил, тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг нар ээлжит сургалтаа хийж мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа. Сургалтанд нийт 188 ажилтан албан хаагч хамрагдлаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 сарын 07-ны өдрийн А/177, А/433-р тушаал даатгуулагчдад эмнэлэгийн хуудас олгох журмыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, ЭМЯ-ны сайд, ХНХЯ-ны сайдын 2023 оны 12 сарын 15-ны өдрийн А/441, А/192 дугаарт хамтарсан тушаалыг танилцуулж, хэрэгжүүлж ажиллах, эрүүл мэндийн төвийн эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх цаашид үйлчлүүлэгчийн диспансерийн хяналтыг сайжруулах, эрүүл мэндийн



магадлалын зөвлөлд илгээж эмчилгээ, оношилгооны дүгнэлтийг стандартын дагуу гүйцэтгэхэд чанарын ахиц гаргах зорилгоор 2024.01.24, 2024.01.26-ны өдрүүдэд магадлагч эмч Я.Баяржавхлан, Нийгмийн даатгалын багц хуулийн талаарх ерөнхий ойлголтыг Тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг нар өгч, сонирхсон асуултанд хариулт өглөө. Сургалтанд БЗД-ийн Эрүүл мэндийн төв, БЗД-Өрхийн эрүүл мэндийн нийт 46 төвийн 68 эмч, сувилагч нар оролцлоо.

Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан тус дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгуулагуудад 2024.02.22, 2024.02.23-ны өдрүүдэд орлого шимтгэлийн тасгийн байцаагч Б.Сауле, Н.Сайнбаяр, Мэдээллийн технологийн ажилтан Г.Энхбаяр, Сургалтын мэргэжилтэн Д.Ангараг нар дүүргийн нийт ажил олгогч болон нягтлан бодогч нарт зориулсан сургалт мэдээллийн цагийг өглөө, өдөр гэсэн 2 ээлжээр нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж шинэ системд нэвтрэн орох, тайлан бэлтгэх, илгээх зэрэг асуудлаар зөвлөн туслаж ажиллалаа. Сургалтанд нийт 120 аж ахуй нэгж байгууллагын 120 нягтлан бодогч оролцлоо.

Хамралтын нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах ажлын хүрээнд

2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчлэгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын



хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахаар НДЕГ-ын даргын 2024 оны 05 сарын 17-ний өдрийн А/79 тоот Болзолт уралдаан зарлах тухай тушаал гарсан. Тушаалын хэрэгжилтийг биелүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын хамралт нэмэгдүүлэх болзолт уралдааныг Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын хэлтэс болон байцаагч нарын дунд 2024 оны 05 дугаар сарын 22-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хугацаанд 180 хоногийн хугацаатай зарлан ажиллаж байна.

2024 онд шинээр 997 ажил олгогч, албан журмын даатгуулагч 4651 хамруулж Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

2024 онд сайн дурын даатгалд 4281 даатгуулагч хамруулсан. Үүнээс 0-3 насны хүүхдээ асарч буй ээж 191, малчин 87, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асар буй эцэг эх 372-г хамруулж, Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулан ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль болон зах худалдааны төвүүдээр сар тутамд хуваарь гарган ажиллаж оюутан





суралцагсад болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдэд эрүүл мэнд, сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар мэдээлэл өгөн ажиллан хамрагдалтыг нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна. Санхүүгийн дэмжлэг хүссэн иргэд, ажил олгогчдыг нийгмийн даатгалд хамруулах, авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах ажлыг дүүргийн ХХҮГазартай хамтран “Хөдөлмөр эрхлэлт 2024” өдөрлөгийн зохион байгуулж ажиллалаа.

Баянзүрх дүүргийн Засаг Даргын 11, 20, 33 дугаар хороодод Малчны сайн дурын даатгалын талаар сургалт хийж сургалтад нийт 57 иргэн хамрагдаж мэдээ мэдээлэл өгч ажилласан.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэн, 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 60 хоногийн хугацаатай авлага барагдуулах аян, 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл 60 хоногийн хугацаатай авлага барагдуулах аяныг тус зарлан, аяны хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажилласан байна.



Нийт байцаагч ажилтнуудад 2024.01.03-наас эхлэн хуулийг дагаж мөрдөн талаар сургалтуудыг зохион байгуулан ажилласан. Мөн шинээр СИКОС системийн программ нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд нийт байцаагч нарт танилцуулга хийх, программд

ажиллах дадлага сургуулилт хийх сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 03-наас 09-ний хооронд зохион байгуулан ажилласан. 2023 оны 06 дугаар сарын 24-нөөс Засгийн газрын 238, 239 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, мөн Засгийн Газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны хуралдаанаар баталсан 2024 оны 04 дүгээр сарын 01-нээс нийт тэтгэвэр авагчдад 100 мянган төгрөгийн нэмэгдлийг олгох ажлыг зохион байгуулан ажиллав.



Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан тус газарт бүртгэлтэй ажил олгогч, нягтлан бодогчдод зориулсан сургалтыг шат дараалан хийж, мэдээллийг өгөн ажиллалаа.

Ажил олгогчийн нягтлан бодогчдод “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүд, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд анхаарах асуудлууд, нэмэгдсэн болон нэршил өөрчлөгдсөн датгуулагчийн төрлийн кодын талаархи мэдээллийг өгөн ажилласан.



Мөн олон нийтийн цахим хэрэгсэл болон баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тайлан өгдөг аж ахуйн нэгж байгууллагын цахим группт мэдээллийг өгөн ажиллаж байна.



ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТООН МЭДЭЭ, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ /тэрбумаар /

Нийгмийн даатгалын
сангийн орлого

422.38

Нийгмийн даатгалын
сангийн зарлага

568.22



295.33

31.13

22.60

5.95



506.02

29.63

3.2

29.4



Ажил олгогч
-997



Албан журмын
даатгуулагч
-4251



Сайн дурын
даатгуулагч
шинээр-4267
0-3 настай
даатгуулагч эх-425,
малчин-87,
ХБЭх-1200



САНГИЙН ЗАРЛАГЫН ЗАРЦУУЛАЛТ

Өндөр настны тэтгэвэр	Тахир дутуугийн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр	ҮОМШӨ-ний ТД, ТА тэтгэвэр
нийт-39735 зарцуулалт-380.40	нийт-5501 зарцуулалт -38.18	нийт-1869 зарцуулалт-12.80	нийт-4362 зарцуулалт -74.62	Нийт-270 зарцуулалт -3.2



ХЧТА тэтгэмж авагч 8075 Зарцуулалт-3.3	Жирэмсэн амаржсаны тэтгэмж авагч 6454 Зарцуулалт-23.4	Оршуулгын тэтгэмж авагч 1399 Зарцуулалт -2.7	Ажилгүйдлийн тэтгэмж авагч 17683 Зарцуулалт-23.7
--	---	--	--



Нийгмийн даатгалын сангийн орлого, төвлөрүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах ажлын талаар

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх:

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын 4 сангийн төлөвлөгөөг жигд ханган биелүүлж 2024 оны 11 сарын 30-ний байдлаар 422,385.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна. Үүнээс: Ажил олгогийн төлсөн шимтгэл 404,435.1 сая төгрөг, Сайн дурын даатгуулгалын шимтгэл 17,551.45 сая төгрөг, бусад орлого (акт, алданги, хүү торгууль) 179,6 сая төгрөг байна. 2024 оны 12 дугаар сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 446,963.0 сая төгрөг төвлөрүүлэн ажиллана.

ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө 2024 оны 11 сарын 30-ны байдлаар 73,631.6 сая төгрөг байгаагаас 68,182,8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр ЭМД-ын санд нийт 80,325.4 сая төгрөг төвлөрүүлэн ажиллана

НДЕГ-ын даргын А/03 тоот тушаалаар батлагдсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Сүүлийн байдлаар хуваарьт өөрчлөлт оруулснаар тус дүүргийн сангийн орлогын төлөвлөгөө 2024 онд 446'650.97 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 11 сарын байдлаар 484'382,10 сая төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан. Энэ нь 108,4 хувьд хүрч байна. Тэтгэмжийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөөний дагуу 29'452,64 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд 30'091.36 сая төгрөгийн зарцуулсан байна. Тэтгэврийн даатгалын сангийн төлөвлөгөөгөөр тэтгэврийн санд 463628.17 сая, үйлдвэрлэлийн ослын санд 3921.1 сая төгрөгийн төлөвлөгөөтэй санхүүжилт орж ирсэн бөгөөд тэтгэврийн даатгалын санд 467228.35 сая төгрөг, 3288.97 сая төгрөг үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зарцуулагдсан. Ажилгүйдлийн даатгалын сангийн төлөвлөгөө 20438.74 сая төгрөг бөгөөд 23774.9 сая төгрөгийн зарцуулалттай байна.

НДЕГ-ын даргын 2024 оны А/03 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай” тушаалаар батлагдсан төсөвтэй танилцан байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах зорилгоор бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулан ажиллаж байна. 2024 онд 2877,66 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй, санхүүжилт 100 хувь олгогдсон. Үүнээс 1820,7 сая төгрөг буюу 93,7 хувийн гүйцэтгэлтэйгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.


Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс бууруулан ажиллаж байгаа бөгөөд тэтгэврийн даатгалын санд тавигдсан улсын байцаагчийн актын дагуу 207,53 сая төгрөгийн суутгал хийж авлага барагдуулсан. Тэтгэмжийн даатгалын сангийн урьд оны авлагаас 1,9 сая төгрөгийг барагдуулсан. Энэ онд 135,12 сая төгрөгийн авлага үүссэнээс 116,14 сая төгрөгийг барагдуулан ажилласан. Ажилгүйдлийн даатгалын сангийн авлагаас 86,5 сая төгрөгийг барагдуулан ажилласан. Мөн газрын даргын тушаалаар авлага барагдуулах комисс байгуулагдсан бөгөөд сангийн нягтлангууд хамтран авлага барагдуулах ажил зохион байгуулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 05/2405 тоот чиглэлд зааснаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн орлогын дансны үлдэгдлийг НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр төвлөрүүлнэ. Нийгмийн даатгалын




ерөнхий газар нь төвлөрсөн орлогын харилцах дансанд төвлөрсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын холбогдох санд хуваарилан шилжүүлж Нийгмийн даатгалын газруудад санхүүжилт олгоно.

Тус газар 11 сарын 30-ны байдлаар нийт 422308,4 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан.




Сангийн орлогын төлөвлөгөөний дагуу сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэл 11 дүгээр сарын 30-ны байдлаар 17'600.0 сая төгрөг төвлөрүүлснээс төрлөөр салгавал:





Сайн дурын даатгалын төлсөн шимтгэлийн орлого /сая.төгрөг/

- Нийт төвлөрүүлсэн гүйлгээг банкуудаар ялган авч үзвэл:



Сангийн орлогын төвлөрүүлэлт /банкар. сая төгрөг/ НДЕГ-ын төвлөрсөн орлогын дансанд нийт төвлөрүүлсэн орлогын 5 сангийн хуваарилалт нь 2024.10.31-ны байдлаар:

Хай нийт 2024 оны 10 сарын байдлаар								
Программаар хуваарилагдсан								
ко	№	Хэлтсийн нэр	Тэтгэвэр	Тэтгэмж	VOMШЭ	Ажилгүйдэл	Эрүүл мэнд	Нийт шимтгэлийн орлого
1	00	Цэвэрлэгээ						
2	01	Архангай	28,234,381.54	2,750,659.56	1,682,932.25	513,012.90	5,909,429.94	39,090,416.19
3	02	Баян-Елгий	34,572,412.18	3,490,002.64	2,022,258.52	708,404.36	8,491,585.45	49,284,643.15
4	03	Баянхонгор	34,202,165.69	563,192.11	467,226.62	42,763.85	7,083,838.42	42,358,886.69
5	04	Булган	22,077,728.83	2,188,049.38	1,395,797.30	406,726.58	4,834,466.68	30,902,768.77
6	05	Говь-Алтай	23,080,925.86	2,312,310.43	1,504,513.04	438,206.82	5,042,831.81	32,378,587.76
7	06	Дорноговь	54,085,466.79	5,629,977.89	6,067,013.17	1,139,812.61	12,012,911.25	78,935,181.71
8	07	Дорнод	41,538,265.82	4,291,403.00	3,826,112.45	818,662.13	9,578,350.97	60,052,794.37
9	08	Дундговь	20,101,956.25	1,149,613.61	777,712.81	199,192.71	4,158,082.75	26,386,558.13
10	09	Завхан	30,072,130.17	2,681,892.35	1,635,482.10	508,951.14	6,940,510.04	41,838,965.80
11	10	Евэрхангай	40,908,999.61	3,982,557.56	2,636,463.56	713,265.06	8,162,071.42	56,403,357.21
12	11	Өмнөговь	123,432,954.47	13,005,195.92	11,469,496.57	2,467,338.59	28,142,424.15	178,517,409.70
13	12	Сихбаатар	25,820,509.04	2,579,772.91	2,107,269.53	497,722.02	5,681,088.99	36,686,339.49
14	13	Сэлэнгэ	57,387,756.79	5,950,737.50	4,179,975.31	1,149,056.30	14,190,249.87	82,857,775.77
15	14	Төв	38,516,577.24	3,908,549.96	2,893,327.80	748,576.70	8,955,233.34	55,022,265.04
16	15	Увс	31,236,389.36	3,108,800.07	2,146,785.29	565,647.00	6,668,436.83	43,727,058.25
17	16	Ховд	39,774,488.59	4,054,147.17	3,093,694.22	777,712.75	9,004,743.01	56,704,785.74
18	17	Хөвсгөл	40,128,110.00	3,951,215.68	2,428,333.37	755,753.16	9,085,848.18	56,349,260.39
19	18	Хэнтий	39,910,259.82	4,081,660.25	2,676,636.28	791,828.64	9,344,417.38	56,804,802.37
20	19	Дархан-Уул	71,840,583.16	7,494,841.33	7,265,729.91	1,481,274.04	16,011,783.03	104,094,211.47
21	20	Орхон	111,699,766.20	11,802,666.72	15,676,719.51	2,424,566.31	25,388,000.81	166,991,719.55
22	21	Говьсүмбэр	16,556,577.07	1,501,241.49	1,472,407.91	296,064.39	3,760,346.22	23,586,637.08
23	23	Чингэлтэй	392,334,003.84	42,114,749.87	47,506,755.11	8,508,947.06	92,731,847.85	583,196,403.53
24	24	Сонгинохайрхан	143,740,170.35	14,978,982.67	11,608,543.78	2,858,088.04	31,340,512.94	204,526,597.78
25	25	Баянгол	323,862,770.19	34,142,918.90	27,305,312.43	6,725,129.10	70,090,736.63	462,126,867.25
26	26	Хан-Уул	371,169,732.77	38,298,059.22	34,300,149.09	7,762,094.00	81,243,877.67	533,812,309.85
27	27	Баянзүрх	268,465,419.92	28,171,993.52	20,401,947.22	5,380,075.27	61,468,413.40	383,887,849.33
28	28	Сихбаатар	409,241,752.92	43,049,363.08	31,835,727.91	8,039,359.43	98,883,738.03	584,546,940.98
29	29	Багануур	25,519,953.55	2,673,009.30	3,278,409.79	543,438.42	5,840,649.88	37,855,460.92



Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөө болон орж ирсэн санхүүжилтийн дагуу зарцуулж байгаа бөгөөд 11 сарын гүйцэтгэлээр тэтгэврийн сангийн төлөвлөгөө 463628,17 сая төгрөг, гүйцэтгэл 467228,35 сая төгрөг буюу 3600,18 сая төгрөгийн хэтрэлттэй байна. Тэтгэмжийн даатгалын сангийн төлөвлөгөө 29452,64 сая төгрөг, гүйцэтгэл нь 30091,36 сая төгрөг байна. ҮОМШӨ-ний даатгалын сангийн төлөвлөгөө 3921,11 сая төгрөг, гүйцэтгэл нь 3288,97 сая төгрөг байгаа бөгөөд 632,14 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан. Мөн ажилгүйдлийн даатгалын сангийн төлөвлөгөө 20438,74 сая төгрөг, гүйцэтгэл нь 23774,9 сая төгрөг зарцуулсан бөгөөд 3336,16 сая төгрөгийн хэтрэлттэй байна.

ТЭТГЭВЭР ОЛГОЛТ БАНКААР:

/сая төгрөг/



2024 оны 10 сарын тэтгэмжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



2024 оны 06 дугаар сарын 11-ний байдлаар байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/03 дугаар “Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай” тушаалын дагуу бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллаар нь зарцуулж нийт санхүүжилт 2877,6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12 дугаар сарын 05-ны байдлаар гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1820,7 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 229.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 33,5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 24,3 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 21,5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр болон бараа үйлчилгээний бусад зардал,



харуул хамгаалалтын зардалд 16,5 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 35,1 сая төгрөг, зөвлөл, хороо комиссын гишүүдийн зардалд 140,8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03-р сарын 18-ны өдрийн А/34 дүгээр тушаал, 2024 оны 04-р сарын 08-ны өдрийн А/47 дугаар тушаал, 2024 оны 05-р сарын 07-ны өдрийн А/67 дугаар тушаал, 6 дугаар сарын 11-ний өдрийн А/100 дугаар тушаал, 7-р сарын 16-ны өдрийн А/129 дугаар тушаал, 9-р сарын 12-ны өдрийн А/153 тоот тушаал, 11-р сарын 12-ны өдрийн А/201 дугаар тушаалуудаар батлагдсан төсөвт 7 удаа өөрчлөлт хийгдсэн. Төсвийн хэмнэлтийн хууль, санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн дагуу зардлыг хэмнэх, зарцуулалтын 6,3 хувиар хэмнэн үр ашгийг дээшлүүлэн ажилласан.

Төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудад нийцүүлэн урсгал зардлын төсвийн гүйцэтгэл, өр авлагын сарын мэдээг сар бүрийн эхний ажлын өдөр үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд нь нийт 12 удаа дээд газарт хянуулж хүргүүлж баталгаажуулсан. Төсвийн гүйцэтгэлийн 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж ННДГ-т хянуулан хүргүүлж баталгаажуулан ажилласан.

Тус хэлтсийн өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам хяналт тавьж, бүртгэл хөтлөн, хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” А/79 дугаар тушаалаар батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг үндэслэн БЗД-ийн Нийгмийн даатгалын газрын даргын “Өмч хөрөнгө, эд аж ахуйн тооллого хийх тухай” тушаалын дагуу 6-р сарын 5-7-ны өдөр үнэн зөв, чанартай хийж тооллогын үр дүнг байгууллагын ӨХБЗ-д танилцуулсан. 2024 оны хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанартай, үр дүнтэй хийхэд анхаарч тооллогын материалыг НДЕГ-ын хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Байгууллагын бүх үндсэн болон үндсэн бус хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалтыг сайжруулах зорилгоор өмч хамгаалах байнгын комиссыг хуваарилан бүх хөрөнгийг биечлэн үзэж танилцаж тоолж бүртгэлийг сайжруулах тал дээр анхааран ажилласан. Албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн картыг зурагжуулах, санхүүгийн программын өөрчлөлт шинэчлэлтийг хийх ажлуудыг эхлүүлсэн. 2024 оны 10-р сарын 25-ны өдрийн 321 тоот албан бичгээр байгууллагын хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа сунгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг актлах 16 хуудас бүхий саналыг хүргүүлсэн. ТӨБЗГ-ын 2020 оны 12-р сарын 28-ны өдрийн 715 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу “Төрийн өмчийг эзэмших гэрээ” –ний дагуу шалгуулж 93 хувьтай дүгнүүлж амжилттай ажилласан. ТӨБЗГ-ын 2024 оны 8 дугаар сарын 394 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын 10-р сарын 02-ны өдрийн А/166 тоот тушаал, НДЕГ-ын 8-р сарын 07-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар нийт 6 нэр төрлийн 39 ширхэг үндсэн хөрөнгийг санхүү бүртгэлд орлогоор бүртгэж, тайланд тусгасан. Байгууллагын газрын 000437367 дугаартай гэрчилгээний хугацаа 2019 онд дууссан байсныг Ланд Овнер ХХК-тай гэрээ байгуулан 382 м2 талбайд Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэн дүгнэлтийг гаргуулан, Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд холбогдох материалуудыг бүрдүүлэн өгч, гэрчилгээний хугацааг шинэчилсэн.

Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж НББ-ийн тухай хууль болон дүрэм журмын дагуу бүртгэлийг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлт авахаар ажиллаж байна. Мөн өмнөх аудитын дүгнэлтээр ирүүлсэн албан шаардлагын биелэлтийг хангахаар ажил зохион байгуулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн өдөр тутмын орлого зарлагын гүйлгээг харилцагч банкаар дамжуулан хэвийн явуулж байна. Өмнөх оны гэрээний биелэлтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлэн ажилласан.



Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй ажилласан. Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн.

НДЕГ болон Ай ти зон ХХК-иас зохион байгуулсан программтай холбоотой цаг үеийн сургалтуудад бүрэн хамрагдаж төвлөрсөн орлого бүртгэх таниулах, өглөг бүртгэх өглөг хаах зэрэг үйлдлийг бүрэн хийж байна. Мөн алдаатай буюу харилцагч таниагүй 172 орлогын гүйлгээ, 162 зарлагын гүйлгээний хуулгыг бүрэн таниулж жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хийж байна. Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу ААНБ тус бүрийн үлдэгдлийг тооцоо нийлэн үлдэгдлийг баталгаажуулан ажилласан. Тус газраас авсан судалгааг тухай бүр хийж явуулсан.

Байгууллагын ажилчдын цалин хөлс, ээлжийн амралт, тэтгэмжийг анхан шатны баримтуудыг үндэслэн зохих журмын дагуу сар бүрийн 8-10, 23-25-нд тогтмол бодож тавьж олгож, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 2236.3 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэй/ өссөн дүнгээр/, 1,820.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл/өссөн дүнгээр/ гарч, нийт 12 удаа бодож тавьж олгосон байна.

Төлөөлөгч, ЭХМК-ын цалин урамшууллыг хурлын тэмдэглэл, цагийн тооцоо бусад анхан шатны баримтуудыг үндэслэн 11 удаа бодож тавьж олгосон. Мөн НДШ, ХХОАТ-ын тайланг гаргаж холбогдох сайтуудад байршуулан илгээсэн.

Нийт батлагдсан төсөв санхүүжилт/төлөвлөгөөгөөр/-2,877.6 сая төгрөг

Гүйцэтгэлээр- 2,877.6 сая төгрөг

Санхүүжилт 100% бүрэн хийгдсэн.

НИЙТ ЗАРЛАГА- 2,321.5 сая төгрөг /12-р сарын 05-ны байдлаар/

1) Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд **1,820.7 сая төгрөг зарцуулсан**
Үүнээс:

- Үндсэн цалингийн зардалд 1,077.3 сая төгрөг
- Нэмэгдэл цалингийн зардалд 392.3 сая төгрөг
- Унаа хоолны зардалд 289.8 сая төгрөг
- Үр дүнгийн урамшуулалын зардалд 61.3 төгрөг тус тус зарцуулагдсан.

2) Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд; **229.0 сая төгрөг зарцуулсан.**

3) Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд: **33.5 сая төгрөг**

- Гэрэл цахилгааны зардал -10.1 сая төгрөг
- Түлш халаалтын зардал – 6.8 сая төгрөг
- Цэвэр бохир усны зардал –3.7 сая төгрөг
- Байрны түрээсийн зардал- 12.9 сая төгрөг

4) Хангамжийн бараа материалын зардал: **24.3 сая төгрөг**

- Бичиг хэргийн зардал – 10.0 сая төгрөг
- Шуудан холбоо, интернэт зардал – 1.8 сая төгрөг
- Хог хаягдал зайлуулах зардал- 1.2 мян төг
- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл- 11.0 сая төгрөг
- Тээвэр, шатахууны зардал- 0,3 төгрөг

5) Эд хогшил, урсгал засварын зардал – **21.5 сая төгрөг**

6) Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, болон бараа үйлчилгээний бусад зардал, харуул хамгаалалтын зардал, өмгөөлөл хуулийн зөвлөхийн зардалд- **16.5 сая төгрөг**

7) Төлөөлөгч, ЭХМК-ын зардалд- **140.8 сая төгрөг**



8) Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардал- **35.1** сая төгрөг тус тус зарцуулагдсан. /2024 оны 12-р сарын 05-ны байдлаар/



Тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгох талаар

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд өдөр тутам шинээр тогтоогдсон тэтгэвэр, ажилласан жил нэмүүлсэн болон цалин өөрчилсөн тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэврийн хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хугацааны өөрчлөлт, тэжээгчээ алдсаны тэтгэврийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн өөрчлөлт зэрэг тэтгэвэрт гарч буй өөрчлөлтүүдийг тухай бүр холбогдох баримт материалыг тэтгэврийн мэдээллийн баазад тулган шалгаж, баталгаажуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд шинээр тогтоосон 2209 өндөр насны тэтгэвэр, 866 тахир дутуугийн тэтгэвэр, 256 тэжээгчээ алдсаны тэтгэвэр, нийт шинээр тогтоогдсон **3331** тэтгэвэр, ажилласан жил нэмүүлсэн 3446, дундаж цалин өөрчилсөн 5311, хөдөлмөрийн чадварын хувь, хугацаа өөрчлөгдсөн 3920, шилжиж ирсэн 430, шилжиж явсан 445, нас барсан 528 тэтгэвэр авагчийн мэдээллийг бүртгэж оруулсан байна.

Тайлант хугацаанд шинээр тогтоогдсон тэтгэвэр, олголтын зардал төрөл тус бүрээр: 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар өндөр насны тэтгэвэр авагч 40718 даатгуулагчид 230.29 тэрбум төгрөг олгосноос 2653 нь иргэн шинээр тогтоолгосон байна. Тахир дутуугийн тэтгэвэр авагч 6452 даатгуулагчид 25.96 тэрбум төгрөгийн тахир дутуугийн тэтгэвэр олгосноос 601 иргэнд шинээр тогтоож олгосон. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 2029 даатгуулагчид 8.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос 196 иргэнд шинээр тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгосон.

Тэтгэвэр тогтоолгосноос хойш нийгмийн даатгалын хуулийн дагуу 1303 иргэний ажилласан жилийн нэмэгдлийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнд өөрчлөлт хийх 175, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан 42, тэжээгчээ алдсаны тэтгэврийн өөрчлөлт /хүүхдийн тоо өөрчлөгдөх/ 43-ийг тус тус цахимаар хийсэн.

Сар бүрийн тэтгэврийн файл явахаас өмнө буюу сарын дундуур баталгаажсан шинэ тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа сунгагдсан тэтгэвэр авагчдын тэтгэврийн мөнгийг 7 хоног бүр банкинд жагсаалтаар бэлтгэн хүргүүлдэг бөгөөд жилийн эцсийн байдлаар 35 удаагийн 5261 тэтгэвэр авагчийн мэдээллийн баазын сунгалт болон олголтыг хянаж, банкинд бэлдсэн файлыг нэгтгэн сангийн нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллаж байна.



Сар бүр давхар регистрийн дугаартай сар (1600 гаруй) нийт давхардсан тоогоор **48447** тэтгэвэр авагчийн мэдээлэл болон олголтыг тэтгэврийн мэдээллийн баазтай мөн улсын хэмжээнд ND LAV-программтай тулган шалгасан. Тайлант хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 1 дүгээр улиралд 64 тэтгэвэр авагчийн 31,555,117 төгрөг, 2 дугаар улиралд 66 тэтгэвэр авагчийн 33,806,843 төгрөг, 3 дугаар улиралд 69 тэтгэвэр авагчийн 36,078,166 төгрөг, 4 дүгээр улиралд 85 тэтгэвэр авагчийн 76,921,328 төгрөгийн авлагыг барагдуулсан.

НДЕГ болон ННДГ-ын хамтарсан шалгалтаар тэтгэвэр илүү олгосон зөрчилтэй 65 тэтгэвэр авагчийн 54,512,917 төгрөг илүү олгогдсоноос 24,065,966 төгрөгийн зөрчлийг барагдуулж 15 тэтгэвэр авагчийн 30,446,951 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсэн болон амаржсан, оршуулга, үйлдвэрлэлийн ослын хөдөлмөрийн чадвар түр алдалт, ажилгүйдлийн тэтгэмжүүдийн анхан шатны материал баримтыг нягтлан шалгаж, хүлээн авч, тухай бүр шалгаж программд оруулж ажилласан. Мөн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан даатгуулагч иргэдийн мэдээллийг тухай бүр нь нийгмийн даатгалын нэгдсэн сангийн цахим мэдээллийн сантай тулган ажиллаж байна.

Тайлант хугацаанд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмж 11714 даатгуулагчид, жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 6220 даатгуулагчид, оршуулгын тэтгэмж 1154 даатгуулагчид, нийт **19088** даатгуулагчийн тэтгэмжийг бодож олгосон байна.

Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 6251 даатгуулагчийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас нийт 90 даатгуулагчийн тэтгэмжийг бодож олгуулсан.

Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасгийн үйл ажиллагааны талаар:

Нийгмийн даатгалын багц хуулийн дагуу 2024 онд шинээр батлагдсан дүрэм, журмын дагуу тус тасаг дараах үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 29-р зүйлийн 29.3-т заасны дагуу 2019 онд дараалсан 6, 2020-2023 онд дараалсан 7 жилийн дунджаар тэтгэврээ тогтоолгосон иргэдийн 2696 хүсэлтийг хүлээн авч тэтгэврийн хувийн хэргийг татуулан тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгсөн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний авч байсан сарын тэтгэврийн 20 хувиар тооцсон дүнгээр нөхөр эсвэл эхнэрийн тэтгэврийг нэмэгдүүлнэ гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 68 тэтгэвэр авагчийн өргөдөл, бүрдүүлэх баримтыг хүлээн авч анхан шатны баримтыг хуулбарлан мэдээллийн баазад оруулж, хувийн хэргийн хамт тэтгэвэр тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгч нэмэгдлийг хийлгэсэн.

Тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйл Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, олгох хугацаанд орсон өөрчлөлтийг иргэд даатгуулагчдад мэдээллийг хүргэн ажиллаж ийн 7.1, 7.2-р заалтыг хэрэгжүүлэн 941 даатгуулагчийн жирэмсэн амаржсаны тэтгэмжийг хүсэлтийг, ихэр хүүхэд төрүүлсэн даатгуулагч эхэд тэтгэмж олгох хугацааг 20 хоногоор нэмэгдүүлсэн хуулийн дагуу 12 хүсэлтийг хүлээн авч, тэтгэмж авах эрх, бүрдлийг шалган, программд үргэлжлүүлсэн. Байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах хуулийн дагуу 171 даатгуулагчийг хүлээн авч гэрээ байгуулан ажилласан.

Монгол улсын Засгийн Газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 450 тоот тогтоолоор баталсан журмын хавсралтад заасан тэтгэвэр шинээр тогтоолгох,



тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журмыг баримтлан иргэдийн материалыг шалган хүлээн авч, бүртгэл хөтлөн, хувийн хэргийг бүрдүүлж, анхан шатны мэдээллийг Sicoc програмд оруулан тэтгэвэр тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгч, мөн Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 438 дугаар тогтоолоор баталсан даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаал, тэтгэмж олгох журам, түүний хавсралтанд заасан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон, амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох болон ажилгүйдлийн тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, даатгуулагчид тэтгэмж олгох харилцааг зохицуулсан журмын хавсралтанд заасны дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн Sicoc програмд оруулж, хүсэлтийг үүсгэн тэтгэмж тогтоолтын байцаагчид хүлээлгэн өгч, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч, иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээний чанар хүртээмж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулан ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.20, 21.21, 21.22, 21.23-р зүйлүүдэд заасны дагуу сайн дурын даатгуулагчийн мэдээллийг программд овог, нэр, регистр, болон хаягийн мэдээлэл, холбоо барих утас зэрэг мэдээллийг үнэн зөв бүртгэн, зөрүүтэй мэдээллийг хамралт, орлогын хэлтсийн даргаар засварлуулан гэрээг байгуулан, шимтгэл ногдуулалтын үнэн зөвийг тухай бүрт шалган, төлөлтийн тооцоог нь бүртгэн оруулж, баталгаажуулалтыг хийн ажиллалаа. Төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй, дутуу төлсөн, тохтолдолд нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.2, сайн дурын даатгалын гэрээний 1.9-т заасны дагуу шимтгэлийн нөхөн төлүүлж, хоцроосон хугацааны алдангийг ногдуулан төлүүлж ажилласан.

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны “Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 215 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн байгууллага өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант жилийн хугацаанд иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын аппликейшныг гар утсанд суулгах, бүртгүүлэхэд зааварчилгаа өгч ажилласан. Дотоод сүлжээ, техник программ хангамжийг зөв эзэмшин ашиглаж иргэд, даатгуулагчдад шуурхай үйлчилж байна. Сайн дурын даатгуулагчид болон ажил олгогч нарын хөдөлмөрийн чадвар алдалт, жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсыг бүртгэх, ажилгүйдлийн материалыг шалган авах бүрдүүлэлтэнд зөвлөгөө өгөн ажилласан. Мөн бүх төрлийн өндөр нас, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвар алдсаны зэрэг тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өөрчлөлт, банк солих, шилжиж ирсэн тэтгэврийн үндсэн материалын бүрдүүлэлтэнд хяналт тавин, холбогдох тушаал шийдвэрүүдийг үндэслэн хүлээн авч байна.

2024 онд тус тасгийн байцаагч нар тэтгэмжийн үйлчилгээг 7869 даатгуулагч иргэнд тэтгэврийн үйлчилгээг 9366 иргэнд, 35294 иргэнд тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зөвлөгөөг, 16284 хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэнд нийгмийн даатгалын хууль болон сайн дурын даатгалын ач холбогдлын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 9162 иргэний сайн дурын даатгалын гэрээг байгуулан шимтгэлийг төлүүлж нийт 83138 иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэн, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулж ажиллалаа.



ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Нийгмийн даатгалын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай А/20 дугаар тушаал”-аар өгөгдсөн чиглэлийн хүрээнд Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан, нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, байгууллагын мэдээллийн самбарт 100 хувь байршуулан ажиллаж байна.

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын цахим хуудсанд, Мэдээллийн самбарт байршуулах нээлттэй мэдээлэлд эхний хасаг жилд 07 дугаар сарын 10-ны өдрийн, жилийн эцэст дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор үнэлгээ хийж, ажиллахыг холбогдох албан хаагчид үүрэг ажиллаж байна. Мөн дээрх ажлын хүрээнд 48 бүлэг 56 нэр төрлийн мэдээллийн төрийн мэдээллийн цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөний дагуу 100 хувьтай байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар нийгмийн даатгалын байгууллагын тухай бүр хэсэгт- 55, сар бүр хэсэгт- 24, жил бүр хэсэгт- 3, нийт 82 мэдээг гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт холбогдох журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу <https://shilendans.gov.mn/> системд 100 хувь хуулийн хугацаанд байршуулан ажилласан.

Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд 2024 оны байдлаар 171 мэдээллийг бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр ханган жилийн эцсийн байдлаар 91 мэдээллийг оруулсан байна.

Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэх чиглэлээр:

Нийгмийн даатгалын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай А/20 дугаар тушаал”-аар өгөгдсөн чиглэлийн хүрээнд нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд 48 бүлэг 56 нэр төрлийн мэдээллийн төрийн мэдээллийн цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж холбогдох мэдээллийг бүртгэх, байршуулах ажлыг тогтоосон хугацаанд байршуулан ажиллаж байна.

.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах, аудит хийж дүгнэлт гаргах ажлын тайлант оны хагас жил болон жилийн эцсийн байдлаар 2 удаа хийж гүйцэтгэж ажиллалаа.

Тус ажлын хүрээнд шилэн дансны хуулийн дагуу нийт *Нийгмийн даатгалын сангийн хувьд нийт 183 /төсвийн гүйцэтгэл-71, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт-39, бусад-73/ мэдээллийг хуулийн хугацаанд бүртгэсэн, 2 мэдээллийг хугацаа хоцроож бүртгэсэн хуулийн хэрэгжилт 98,9 хувьтай байна .

*Нийгмийн даатгалын байгууллагын санхүү /үйл ажиллагаа/-ийн нийт 183 /төсвийн гүйцэтгэл-71, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт-39, бусад-73/ мэдээллийг хуулийн хугацаанд бүртгэсэн, 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан хуулийн хэрэгжилт 99,4 хувьтайгаар хуулийг хэрэгжүүлж ажилласан талаар аудит хийж дүгнэлт гаргаж НДЕГ-т хүргүүлэн ажилласан байн

Нэг. Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын даргын баталсан 01 тоот удирдамжийн хүрээнд: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах,



хянах, баталгаажуулах, архивын нэгж болгосон байдалд хяналт, шалгалтын хийх ажлын хүрээнд Шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 20-ний өдрийг дуустал хугацаанд 2023 оны 01-12 саруудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан /ЗНД-7, ЗНД-8/-г хүлээн авч, хянаж баталгаажуулсан байдлыг шалгалаа.

Мэдээллийн санд 14756 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй Үүнээс:

- Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа - 8254
- Идэвхгүй-2255
- Зогссон болон татан буугдсан бүртгэлтэй - 3752
- Шилжиж явсан хөдөлгөөнтэй 495 ААНБ байна.

Шалгалтын явцад нийт 8254 ААНБ-ын тайланг цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлсэн байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж өгч ажиллалаа.

Тухайлбал: Тус тасаг нь авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

Үүнд:

1. Уулзалт зохион байгуулсан-1032,
2. Албан шаардлага хүргүүлсэн-1297,
3. Данс хаасан-3942,
4. Гэрээ байгуулсан-504
5. Шүүхэд шилжүүлсэн-53 г.м арга хэмжээ авч ажилласан байна.

Нийт давхардсан тоогоор 6828 ААНБ-д дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн боловч өр авлага өмнөх оноос 7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа тухайн ажлыг эрчимжүүлэх, сайжруулах шаардлагатай байгааг дурдсугай.

Мөн хуримтлагдсан өртэй буюу 120 хоногоос дээш шимтгэлийн өртэй 2751 ААНБ-ын 44,7 тэрбум төгрөг, нийт авлагын 75 хувийг эзэлж байна.

Шимтгэл төлөлтийн тайлан баталгаажуулсан тайлангаас дараах зөрчил, дутагдал илэрлээ. Тухайлбал:

- ✓ Шимтгэл төлөлтийн тайлан /ЗНД-7, ЗНД-8/ мэдээллийн сантай шимтгэлийн үлдэгдэл зөрүүтэй -30
- ✓ Ажил олгогч байгууллагын тамга, тэмдэг дарж баталгаажаагүй -27
- ✓ Байцаагчийн тамга тэмдэг дарагдаагүй-25
- ✓ Ажил олгогч байгууллагын удирдлагын гарын үсэг зурагдаагүй баталгаажаагүй-12
- ✓ Байцаагчийн гарын үсэг зурагдаагүй-20
- ✓ Шимтгэл төлөлтийн тайлан /НД-7, НД-8/-г тайланг цахимаар авч мэдээлэлд оруулсан боловч байгууллагын цаасан тайлан ирүүлээгүй -277
- ✓ Тоон гарын үсгээр тайлан илгээдэг ААНБ-1147
- ✓ Үйл ажиллагаа нь зогссон төлөвтэй ААНБ-г хөдөлгөөний төлөвийг засалгүйгээр тайланг татсан байх
- ✓ Ажил олгогч байгууллагын талаарх мэдээллийг /үндсэн мэдээлэл, утасны дугаар, хаяг байршил/ шинэчлэлт муу байна.
- ✓ ҮОМШӨ-ны даатгалыг 1,8-2,8 хувиар төлдөг ААНБ-ыг ердийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр буюу 550000 төгрөгөөр тайлан хүлээн авч баталгаажуулсан; /салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлаагүй/

Цахим хяналтын программын мэдээллээр давхардсан тоогоор Ажил олгогч байгууллагын даатгуулагчийн төрөл буруу -890, Ажил олгогч байгууллагад цалин өөрчилсөн мэдээлэл -3243, Ажил олгогч байгууллагад регистрийн дугаарын нэгтгэсэн -397 тоо гарсан байдалд дүгнэлт, зөвлөмж өгч илэрсэн зөрчлийг арилгуулж ажиллалаа.

Хоёр. Цахим хяналтын шалгалтын хүрээнд мэдээллийн сангийн шинэчлэлтэй холбоотойгоор зөрчлийг илрүүлэх, илэрсэн зөрчлийг тухай бүр хянаж шалгаж шийдвэрлэн ажиллаж байна.




Гурав. 2023 онд шинээр тогтоосон тэтгэврийн тогтоолт олголтод хяналт шалгалт хийх ажлын хүрээнд-Тэтгэврийн мэдээллийн санд бүртгэлтэй нийт 3876 иргэний хувийн хэрэгт авагдсан материалд үндэслэн хяналт шалгалтыг 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалтаар 14 тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолт, зөрүүтэй тогтоогдсон зөрчил илэрч 10 иргэнтэй холбоотой 1,4 сая төгрөгийг төлүүлэх, 3 иргэнтэй холбоотой 1,6 сая төгрөгийн тэтгэврийг нөхөн олгох улсын байцаагчийн акт тогтоож мөн 103 тэтгэвэр авагчийн жагсаалтыг хүргүүлж зөрчлийг арилгуулж ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан байна;

Дөрөв. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг “Хонгор кэй жи ХХК”-ны 2018-2023 оны санхүү, татварын тайланд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар тус байгууллага нь 2018-2023 оны нийт цалингийн сангаас ҮОМШӨ-ний даатгалын сангийн 1 хувийн зөрүүг дутуу тайлагнасан зөрчил илэрсэн тул улсын байцаагчийн актаар нөхөн төлүүлэхээр шийдвэрлэв.

Тав. Нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлтэй 2023 оны жилийн эцсийн тэтгэврийн хувийн хэрэгт хяналтын тооллого хийх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 24-ний хооронд хийж гүйцэтгэлээ. Дээрх ажлын хүрээнд мэдээллийн санд бүртгэлтэй нийт **51215** тэтгэврийн хувийн хэргийг тооллогод хамруулж ажиллахад тооллогын үр дүнгээр нийт **34** тэтгэвэр авагчийн хувийн хэрэг дутсан ба тооллогын явцад олж зөрчлийг арилгуулж ажиллах талаар үйлчилгээний тасагт жагсаалтыг хүргүүлж зөрчлийг арилгуулж ажилласан;



Зургаа. Нийгмийн даатгалын сангаас 2023 оны 01-12 дугаар саруудад олгосон нийт **51215** иргэний тэтгэврийн олголтыг шалгах ажлыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулан ажилласан байна.

Шалгалтаар: Улсын байцаагчийн 002700088 тоот актаар 10 иргэнд илүү олгосон 5,6 сая төгрөг, 28 иргэнд дутуу олгосон 10,2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж ажилласан бөгөөд актаар тогтоогдсон төлбөр, зөрчлийн барагдалт 75,3 хувьтай байна.

Долоо. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг “Нью флат ворлд ХХК”-ны 2018-2023 оны санхүү, татварын тайланд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Тус байгууллага нь 2018 он 11 даатгуулагчтай 28,3 сая төгрөгийн цалингийн сангаас 6,9 сая төгрөгийн шимтгэл, 2019 он 17 даатгуулагчтай 149,3 сая төгрөгийн цалингийн сангаас 35,8 сая төгрөгийн шимтгэл, 2020 он 17 даатгуулагчтай 111,5 сая төгрөгийн



цалингийн сангаас 26,7 сая төгрөгийн шимтгэл, 2021 он 7 даатгуулагчтай 39,7 сая төгрөгийн цалингийн сангаас 9,5 сая төгрөгийн шимтгэл, 2022 он 5 даатгуулагчтай 76,7 сая төгрөгийн цалингийн сангаас 18,4 сая төгрөгийн шимтгэл, 2023 он 6 даатгуулагчтай 78,1 төгрөгийн цалингийн сангаас 18,7 сая төгрөгийн шимтгэлийг тус тус нийгмийн даатгалын санд төлж ажилласан бөгөөд дээрх хугацаанд хуулийн ямар нэгэн зөрчил, дутагдалгүй хуулийг хэрэгжүүлж ажилласан тул зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

5.Нийгмийн даатгалын ерөнхий газар, IT Zone компанитай хамтран салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлж буй GREEN ERP хүний нөөцийн программд тус газарт бүртгэлтэй нийт 101 албан хаагчийн /үндсэн ажиллаж буй ажилтан, нийгмийн даатгалын төлөөлөгч, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүд, жирэмсний болон амаржсны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй эхчүүд/ төрийн албан хаагчийн анкет, хувийн мэдээллийг /банкны данс, ажил эрхлэлтийн түүх, ээлжийн амралтын цикл, хуваарь, ирцийн мэдээ... гэх мэт/ албан хаагч тус бүрээр шинээр бүртгэж ажилласан. Албан хаагчийн цахим хувийн хэргийг өдөр тутамдаа хөтлөн, баяжуулж, шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг өөрчлөлт орсон тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

6.2024 оны жилийн эцсийн байдлаар газрын даргын хүний нөөцтэй холбоотойгоор 119-н тушаалын төслийг бэлтгэж, албажуулсан. /А тушаал-33, Б тушаал-86/

7.Тайлант хугацаанд хүний нөөцийн хөдөлгөөний мэдээг сар бүр гарган Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна. Газарт хийгдэж байгаа хүний нөөцийн хөдөлгөөн нь: шилжин ирсэн 4, шилжин явсан 5, Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилдаа буцаж томилогдсон 5, Жирэмсний болон амаржсны, хүүхэд асрах чөлөө авсан 3, богино хугацааны чөлөө авсан 3, өөрийн санаачлагаар ажлаас чөлөөлөгдсөн 6 ажилтан, нэгж хооронд шилжин томилогдсон-16, өндөр насны тэтгэвэрт гарсан 1, шинээр ажилд орсон 11 албан хаагч байна.

Албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухай бүр хүний нөөцийн программд /5-н программ/ бүртгэж, төрийн албан хаагчийн хувийн хэргийг цаасаар болон цахимаар баяжилтыг тухай бүр хийж, хадгалж байна.

8. Нийгмийн даатгалын салбарт үр бүтээлтэй ажилласан, ажил үйлсээрээ шалгарсан 35-н албан хаагч нарын шагналын материалыг дээд газарт хүргүүлэн ажиллаж байна.

9.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийт албан хаагчдад бэлэг олгох ажлыг зохион байгуулсан.

10.Газрын нийт 75 ажилтны төрийн албан хаагчийн хувийн хэргийг Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмын дагуу шинэчлэн цэгцэлж, баяжуулсан. Мөн ажилд шинээр томилогдсон, урт хугацааны чөлөөний хугацаа нь дуусаад ажилдаа эргэн орсон, нийгмийн даатгалын төлөөлөгчөөр ажиллаж буй нийт 21 ажилтны хувийн хэргийг шинээр баримт бичгийн бүрдлийн дагуу



цуглуулж, үүсгэсэн. Мөн төрийн өөр байгууллагад шилжин ажилласан 5 албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу хүлээлгэн өгсөн.

11.Газрын нийт ажилтантай холбоотой бүх төрлийн судалгааг /12 төрлийн судалгаа/ харьяалагдаж буй нэгж бүрээр шинэчлэн гаргаж өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон, удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна.

12.Нийслэлийн нийгмийн даатгалын газраар дамжуулан зэрэг дэв шинээр авах 5 ажилтан, зэрэг дэв нэмүүлэхээр 11 ажилтан нийт 16 ажилтны холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлснээр Нийслэлийн засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/369 тоот захирамж гарч, тус 16 ажилтанд зэрэг дэв болон түүний нэмэгдлийг газрын даргын тушаалаар олгуулсан. Мөн нийт 75 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг олгосон.

13.Мэргэшлийн тэргүүлэх зэрэг 9-н улсын байцаагч, зөвлөх зэрэг 20-н улсын байцаагчид олгуулахаар холбогдох материалыг дээд газарт хүргүүлэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/80 дугаар тушаалаар Мэргэшлийн зэрэг олгон шийдвэрлүүлсэн.

14.Тайлант хугацаанд шинээр ажилд орсон 11, шилжиж ирсэн 4 ажилтанд байгууллагын дотоодод дагаж мөрдөх дүрэм, журам, төрийн албаны тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт, ажлын цаг ашиглалтын талаар ганцаарчилсан сургалтыг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

15. GREEN ERP хүний нөөцийн программд тус газарт бүртгэлтэй нийт 93-н албан хаагчдаас идэвхтэй 75-н албан хаагчдад Sicos программд ажиллах хэрэглэгчийн эрхийг тухай бүр нээж өгч ажилласан.

16. Салбарын хэмжээнд ашиглагдаж буй программ болох ABLE дээр идэвхтэй ажиллаж буй 75-н албан хаагчийг тухай бүр GREEN ERP хүний нөөцийн программын кодтой давхцуулан ABLE программд кодыг бүртгэн, цагийн бүртгэлийн машинд холбуулан ажиллаж байна.

17. Тайлант хугацаанд хүний нөөцийн хөдөлгөөний мэдээг Нийслэлийн нийгмийн даатгалын газарт сар тутам нийт 5-н удаа, Нийгмийн даатгалын ерөнхий газарт 7-н удаа тус тус хүргүүлэн ажилласан бөгөөд орон тооны хэтрэлгүй ажиллаж байна.

18. Нийгмийн баталгааг хангах 3 зорилт, 14 ажил үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд нийт 11-н албан хаагчид буцалтгүй тусламж олгосон. 30-н Ахмад настанд 2 удаа хүндэтгэл үзүүлэн урамшуулал олгосон. Удирдлагын академийн Ахлах түшмэлийн сургалтанд 3-н албан хаагч, нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд 1 албан хаагч хамрагдах хугацаанд цалинтай чөлөө олгон дэмжин ажиллаж байна. Нийт 67-н албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, шинжилгээ өгүүлэн, өдрийн эмчилгээ хийлгүүлсэн.

19.Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газраас ирсэн нийт 15-н албан бичиг, захирамж, удирдамжийн хүрээнд олон нийтийг хамарсан цаг үеийн арга хэмжээнд бүх албан хаагчдаа хамруулан тайлан мэдээг гарган ажиллалаа.

20. ABLE программаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүний нөөцтэй холбоотой нийт 21-н албан бичиг ирснийг тухай бүр танилцан тайлан мэдээг гарган, хариуг хүргүүлсэн.

21. Тайлант хугацаанд 2024 онд шинээр ажилд орсон 11, шилжиж ирсэн 4 ажилтанд болон газрын нийт 75-н албан хаагчдад хүний нөөцийн программуудтай ажиллах ганцаарчилсан сургалтыг давхардсан тоогоор 108 албан хаагчдад зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Монгол бичгийг дунд шатны нийт 8-н удаагийн сургалтанд хамрагдан, суралцсан. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулдаг Төрийн албаны вебинар сургалтанд долоо хоног бүр тогтмол



хамрагдан, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль журмын талаарх мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна.

22.Байгууллагын нийт ажилтантай холбоотой бүх төрлийн судалгааг /18 төрлийн судалгаа/ харьяалагдаж буй нэгж бүрээр шинэчлэн гаргаж өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон, удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, түүнд хяналт тавьж ажиллах

2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай Засгийн газрын тогтоолын хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус хэлтэс нийт 5-н зорилтын хүрээнд 20-н ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө гарган бүрэн хэрэгжүүлж ажилласан. Авлигын нийгмийн хор аюул, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор газрын цахим хуудсаар “Авлигын эсрэг ...НЭГДЬЕ” постыг 12 удаа сурталчилж 84-н албан хаагч хуваалцсан байна. Нэг давхарын зурагтаар дүрст сурталчилгааг “Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк” иргэд болон албан хаагчдад байнгын хүргэж байна. Нэг цэгийн зөвлөгөө мэдээллийн самбарт “Авлигын эсрэг ...НЭГДЬЕ” шүгэл аяны зурагт хуудсыг байрлуулаад байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын газрын албан хаагчид нийт 65 байцаагч, ажилтнуудыг авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигын тухай хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон “Хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх” тухай мэдээлэл өгөх 2 удаагийн сургалт, 1 удаагийн уулзалтыг Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх хэлтэс, сургалт олон нийттэй харилцах, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран зохион байгуулж ажилласан байна.

Баянзүрх дүүргийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан 2 удаагийн ЭБАТ-ын сургалтад хяналт шалгалтын байцаагч нарыг хамруулан ажилласан.

Авлигын нийгэм учруулах хор аюу, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор газрын цахим хуудсаар дамжуулан “Авлигын эсрэг ... НЭГДЬЕ” постыг 21 удаа, нийтэлж бусадтай мэдээллээ хуваалцаж, түгээсэн.

Мөн Авлигатай тэмцэх гараас бэлтгэсэн богино хэмжээний бичлэг, зурагт хуудсыг иргэд, даатгуулагч болон ил харагдахуйц газар байршуулан ажиллаж байна.

* Нийгмийн даатгалын байгууллагын албан тушаалтны сахилга хариуцлага, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх, албан хаагчтай холбоотой ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, иргэд даатгуулагчдын эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах ажлыг зохион байгуулж байцаагч ажилтны харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой иргэд, даатгуулагчаас ирүүлсэн 6 гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж холбогдох газруудад хариуг хүргүүлж ажилласан байна.

* Монгол Улсын Их хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний хурлаар баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд нийт албан хаагчдын саналаар хэлтсийн Ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж, хорооны гишүүдийг баталгаажуулан ННДГ, НДЕГ-т хүргүүлж ажиллалаа.

Нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудын ажлын байрны стандарт, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос 3 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 125 байцаагч ажилтнуудыг хамруулж



ажиллалаа. /Төрийн албан хаагчийн ёс зүйг хэмжээ, харилцаа хандлага болон үйлчилгээний стандарт, биеийн хэл, /

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллаж байна.

Тухайлбал:

Нэг. Авлигатай тэмцэх газартай хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг хэлтсийн дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс /ЭХМК/-ийн гишүүд болон дүүргийн эмнэлэг хяналтын комисс /ЭХК/, нийт ерхийн эрүүл мэндийн төвийн дарга нарыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан;

Хоёр. Биеийн хэлийг харилцаан дээр үр дүнтэй ашиглах нь сэдэвт сургалтыг сэтгэл засал судлал, Сэтгэцийн эмгэг судлалын ахлах зэргийн эмч П.Болортуяа нийт хэлтсийн ажилтан албан хаагчдад “харилцааны ёс зүй, бие ээ хэрхэн авч явах, сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголт,...” мэдээлэл, сургалтыг зохион байгуулж ажилласан;

Гурав. Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах, байцаагч, ажилтнуудыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, шинэ байцаагч ажилтнуудыг мэргэшүүлэх 14 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 125 шинэ ажилтан, алба хаагчдыг хамруулан ажилласан байна.

Дөрөв. Харилцаа хандлага, ёс зүй сэдэвт сургалтыг Полис төвийн захирал н.Эрдэнэгэрэлтэй хамтран 1 удаагийн сургалтыг зохион байгуулж газрын 57 байцаагч ажилтнууд хамрагдсан.

Тав. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах Нийгмийн даатгалын багц хуулийн талаарх ойлголтыг сайжруулах ажлын хүрээнд 12 удаагийн сургалтаар 95 хүнийг хамруулан “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэврийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль”. “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, “Байгууллагын хүний нөөцийн бодлого, баримлах зарчим...” зэрэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж ажиллалаа.

Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, хуулийг сурталчлах, нийтэд мэдээлэл өгөх ажлын хүрээнд 27 удаагийн сургалтаар 174 ААНБ-ын 2899 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Тухайлбал: Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбогдуулан ШШГЕГ-ын харьяа 409 дүгээр хаалттай хорих ангид 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн тус ангитай хамтран зохион байгуулж ажилласан, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб үйлчилгээ, аж ахуйн хэлтэстэй хамтран Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч нийт 150 гаруй алба хаагчид хамрагдсан сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, ажил хөдөлмөр эрхлээгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгч Нарантуул, Дүнжингарав, Сандэ худалдааны төв... г.м худалдааны төв, захуудад ажиллаж байгаа бизнес эрхлэгч иргэд, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургууль болох



Отгонтэнгэр их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Дотоод хэргийн их сургууль, БЗД-ийн алслагдсан хороод 11, 20, 23, 27, 28 дугаар хороодод уулзалт сургалт сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 7296 иргэд даатгуулагчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулсан талаар

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээний ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Баянзүрх дүүргийн нийгмийн хэлтэс” фэйсбүүк аккаунт /25000 найзтай, бусад нь дагагч/, фэйсбүүк хуудас /6490 дагагчтай/ тус тус тогтмол ажиллуулан мэдээллийг түгээж байна. Нийгмийн даатгалын байгууллагын хувьд 2024 оны “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”, Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах ажлыг газрын цахим хуудас болон олон нийтийн сүлжээг ашиглан 4 удаагийн LIVE, 61 удаагийн пост /мэдээлэл/ түгээж иргэд даатгуулагчдын хандалт, сэтгэгдэлд дүгнэлт хийж зөвлөгөө, мэдээлэл түгээн ажиллаж байна.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйжээр хийсэн шимтгэлийн тайлан илгээх, даатгуулагчийн төрөл, шимтгэл ногдуулах орлого сэдвээр НДЕГ-ын ХШГ-ын дарга С.Лхагвадоржтой хамт мэдээл өгч, холбогдох асуултанд хариулж ажиллалаа. “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд НДЕГ-аас зарласан Нээлттэй мэдээллийн сар болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлах, тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай хууль болон шимтгэл төлөлтийн талаар НДЕГ-аас гаргасан цаг үетэй холбоотой LIVE мэдээ, мэдээлэл постыг тухай бүрт нь түгээн 16,2к хандалттайгаар ажилласан

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэргэжлийн болон үйлчилгээний ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх чиглэлээр, сургалт сурталчилгаа

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр гарын даргаар батлуулан 4 арга хэмжээний хүрээнд 11 ажил хийх төлөвлөгөө гарган мөрдлөг болгон ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/45 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “ХАСХОМ-1” буюу “ХАСХОМ-ийн 2023 оны тайлан”-ийн маягт, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/122 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсан “ХАСХОМ-2” маягтын дагуу 2023 онд 42 албан тушаалтан “ХАСХОМ” гаргаж 2024 оны 02 дугаар сарын 20-нд НДЕГ-т тайланг хүргүүлсэн.

“Нийтийн албанд Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.2.2, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор баталсан маягтын дагуу газрын хэмжээнд 2024 оны хагас жилийн байдлаар 6 албан хаагчын “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн дүгнэлт гаргуулан <https://meduuleg.iaac.mn/> цахим системд бүртгэн ажиллаж байна.

“Нийтийн албанд Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд:



Шүүх шинжилгээний ерөнхий газрын "Бичиг баримтын бүрдэл хэсгийн хуурамч байдлыг тодруулах" сургалт 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нийт 54-н албан хаагчийг хамруулан, Тэтгэмжийн материал хүлээн авах, хянахад хэрхэн анхаарах, хуурамч материалыг яаж ялгах талаар ШШЕГ-ын Эрдэмтэн нарийн бичгийн дарга бөгөөд Эрдэм шинжилгээ, сургалт, хөгжүүлэлтийн төвийн дарга, доктор цагдаагийн хошууч М.Түмэннаст орсон.

Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Д.Золжаргал "Авлигын эсрэг гэмт хэрэг"ийн талаарх сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 04-нд газрын нийт албан хаагчдад зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан дагалдаж гарсан журмуудын хүрээнд болон НДЕГ-ын дотоод журам, байгууллагынхаа дотоод журмыг боловсруулан газрын даргын 2024 оны 01 сарын 11-ний өдрийн А/05 дугаар тушаалаар баталж ажилтан, албан хаагчдад танилцуулан мөрдөн ажиллаж байна.

Хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн үнэн зөв гаргах сэдвийн хүрээнд АТГ-ын мэргэжилтэн Б.Саруулзаяа 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нийт 58-н албан хаагчдад "Хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн үнэн зөв гаргах вэ?" сэдвээр сургалт хийсэн.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан 4 удаагийн сургалтад 36 эмч, мэргэжилтнийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1 удаагийн сургалтад зөвлөлийн нийт гишүүдийг хамруулж ажилласан байна.

Нийгмийн даатгалын программын шинэчлэлийн хүрээнд SICOS программд шинээр тэтгэмжийн материал хэрхэн оруулах талаарх сургалт 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Шинэ программд тэтгэмжийн мэдээллийг хэрхэн оруулах, анхаарах асуудал, материал хэрхэн хүлээн авах цаашид анхаарах асуудлуудаар нэг цэгийн байцаагч нарт тэтгэмжийн байцаагч Б.Орхон, Л.Дүүриймаа нар сургалт орж ажилласан.

Мэдээллийн технологийн мэргэжилтэн Г.Энхбаяр албан хаагчдад тухайн сэдвээр сургалт орж, Мэдээллийн технологийн аюулгүй ажиллагааг таниулах, албан хаагчдын анхаарвал зохих чухал асуудлуудыг ярилцав. Нийт 2 удаагийн сургалтанд 63 албан хаагч оролцсон. Тэтгэврийн материал хэрхэн хүлээн авах, материал хүлээн авах шинэчлэсэн журмын талаар Үйлчилгээний тасгийн дарга Д.Гэрэлцэцэг танхимын сургалт орсон.

Тус хэлтэс нийт 5-н сургагч багш бэлтгэн, байцаагч ажилтнуудадыг багт хуваан, сургалтын төлөвлөгөө гарган, өдөр бүр өглөө 08.00-09.00 цагт сургагч багш нараар байцаагч, шинэ ажилтнуудыг чадавхижуулах "Нийгмийн даатгалын тухай хууль"-д орсон нэмэлт өөрчлөлтүүд, "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр нийт 36 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 628 албан хаагчид зохион байгуулсан.

Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийн нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудыг чадавхижуулах сургалтад тус тасгийн 6 байцаагч, магадлагч бүрэн хамрагдсан мөн газрын байцаагч ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг өдөр бүр тогтмол зохион байгуулж сургалтын төлөвлөгөөний дагуу 8 удаагийн сургалтад хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын программын шинэчлэлийн хүрээнд SICOS программд хэрхэн нэвтрэх, ажиллах, даатгуулагч хэрхэн бүртгэх, ажиллуулах, дадлагажуулах 7 удаагийн сургалтанд 2024 он 01-р сарын 10-наас 01-р сарын 12-ны өдрүүдэд, Мөн НДЕГ-аас хийсэн цахим сургалтанд 2 удаа, танхимын сургалтанд 1 удаа хамрагдсан.

Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэн батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байгаатай холбоотойгоор хуулийн шинэчлэлийг дагаж



гарсан журам, дүрэм, зөвлөмж, чиглэл зэрэг байцаагч ажилтнуудын мэдэж, судлахуйц баримт бичгийг агуулсан 8 бүлэг цахим гарын авлага /байцаагчийн туслах/-ыг боловсруулан нийт байцаагч ажилтнууд өдөр тутмынхаа ажилд хөтөч, цахим туслагч, зөвлөгч хэлбэрээр 2024.11.01-ний өдрөөс нэвтрүүлэн өдөр тутмын ажилдаа ашиглаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

-Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт нийт 18-н удаагийн давхардсан тоогоор 430 албан хаагчдад зохион байгуулсан.

Нэг. Авлигатай тэмцэх газартай хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг газрын дэргэдэх эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс /ЭХМК/-ийн гишүүд болон дүүргийн эмнэлэг хяналтын комисс /ЭХК/, нийт өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан;

Хоёр. Биеийн хэлийг харилцаан дээр үр дүнтэй ашиглах нь сэдэвт сургалтыг сэтгэл засал судлал, Сэтгэцийн эмгэг судлалын ахлах зэргийн эмч П.Болортуяа нийт газрын ажилтан албан хаагч нарт “харилцааны ёс зүй, бие ээ хэрхэн авч явах, сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголт, ...” мэдээлэл өгүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан;

Гурав. Ч.Өнөржаргал/ -тай хамтран зохион байгуулахаар төлөвлөж ажиллаж байна. Байгууллагын болон ажилтан албан хаагчдын үйлчилгээ болон үйл ажиллагааны талаарх сэтгэл хангамжийн судалгааг 2 удаа зохион байгуулж ажилласан байна.

Үүнд: 1. Байцаагч ажилтнуудын / цалин хөлс, ажлын ачаалал, ажиллах орчин нөхцөл/ ... г.м сэтгэл ханамжтай байгаа эсэх талаарх судалгаа;

2. Нийт байцаагч ажилтнуудын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг хэрэглэгч буюу иргэд, даатгуулагчдаас авч дүгнэлтийг нэгтгэн гаргаж газрын даргын зөвлөлд танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

*Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмжийн даатгалын сангаас олгох ЖА болон ХЧТА-ны тэтгэмжийн эмнэлгийн хуудас олгох журмыг танилцуулах, хэрэгжүүлж ажиллах сургалтыг дүүргийн Эрүүл мэндийн төвүүд, өрхийн эрүүл мэндийн төв, бусад төрийн нэгдсэн эмнэлгүүдийн ажилтнуудад цахим сургалтыг зохион байгуулж ажилласан;

Мэдээллийн технологийн мэргэжилтэн Г.Энхбаяр албан хаагчдад тухайн сэдвээр сургалт орж, Мэдээллийн технологийн аюулгүй ажиллагааг таниулах, албан хаагчдын анхаарвал зохих чухал асуудлуудыг ярилцав.

Нийтийн хурал болон цахим группийг ашиглан нийт албан хаагчдад цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ дээшлүүлэх сургалт, зөвлөгөөг мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн Г.Энхбаяр өгч ажиллаж байна. Мөн компьютер ашиглаж байгаа нийт албан хаагчдад гадны санах ой буюу флаш, зөөврийн хатуу диск зэргийг компьютерт холбохгүй байх талаар мэдээллийг байнга цаг алдалгүй хүргэж байна. Нэг цэгийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийн төвийн нийт байцаагч ажилтнуудад Үйлчилгээний тасгийн дарга Д.Гэрэлцэцэг тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах журмын дагуу тэтгэвэр, тэтгэмжийн материалыг хэрхэн хүлээн авахад юуг анхаарах, материал хэрхэн бүрдүүлж авах талаарх сургалтыг өдөр бүр 07.30-08.30 цагийн хооронд 5 удаа зохион байгуулж ажилласан.

Нийт 5-н сургагч багш бэлтгэн, байцаагч ажилтнуудадыг багт хуваан, сургалтын төлөвлөгөө гарган, өдөр бүр өглөө 08.00-09.00 цагт сургагч багш нараар байцаагч, шинэ ажилтнуудыг чадавхижуулах “Нийгмийн даатгалын тухай хууль”-д



орсон нэмэлт өөрчлөлтүүд, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр нийт 39 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 396 албан хаагчид зохион байгуулсан.

Тайлант хугацаанд 2024 онд шинээр ажилд орсон 11, шилжиж ирсэн 4 ажилтанд болон газрын нийт 75-н албан хаагчдад хүний нөөцийн чиглэлээр хүний нөөцийн программуудтай ажиллах ганцаарчилсан сургалтыг давхардсан тоогоор 108 албан хаагчдад зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Байгууллагын давхар тус бүрт байрлах мэдээллийн самбарт хуулийн өөрчлөлттэй холбоотой шинэ гарсан зөвлөгөө мэдээллийг тухай бүрт нь шинэчлэн оруулж сурталчлан ажиллаж байна.



Нийгмийн даатгалын үйлчилгээг ажил олгогч, даатгуулагчдад сурталчлах, сургалт, мэдээлэл өгөх ажлын хүрээнд ажлын хүрээнд

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт сэдвээр 2024.01.11, 2024.01.12-ны өдрүүдэд 3 удаагийн сургалтыг Амгалан Дулааны Цахилгаан Станц, Сtimo ХХК,



Е-Март худалдаа үйлчилгээний төвийн ажилтан албан хаагч нарт орлого шимтгэлийн байцаагч Б.Сарантуяа, Н.Сайнбаяр, Ж.Цэцэгсүрэн,



тэтгэмжийн байцаагч М.Шинэжил, тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг нар ажиллаж, орлого шимтгэл, тэтгэвэр, тэтгэмжийн талаарх мэдээлэл зөвлөгөө өгч, даатгуулагчийн сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан. Сургалтанд нийт 445 ажилтан албан хаагч хамрагдлаа.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт сэдвээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Х.Булгантуяагийн ажлын албатай хамтран 2024.01.16-2024.01.23-ны өдрүүдэд 3 удаагийн сургалтыг СЭМҮТ, РИХА мед эмнэлэг, ПЕТРОСТАР группийн ажилтан, албан хаагч нарт орлого шимтгэлийн байцаагч Энэрэлт, Алтанцог, Цэцэгсүрэн, тэтгэмжийн байцаагч М.Шинэжил, тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг нар ээлжит сургалтаа хийж мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа. Сургалтанд нийт 188 ажилтан албан хаагч хамрагдлаа.



Сургалт, мэдээллийн цаг. Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан 2024.03.12-ны өдөр орлого шимтгэлийн тасгийн байцаагч Б.Сауле, Н.Сайнбаяр, Мэдээллийн технологийн ажилтан Г.Энхбаяр, Сургалтын мэргэжилтэн Д.Ангараг нар дүүргийн нийт ажил олгогч болон нягтлан бодогч нарт зориулсан сургалт мэдээллийн цагийг зохион байгуулж шинэ системд нэвтрэн орох, тайлан бэлтгэх, илгээх зэрэг асуудлаар зөвлөн туслаж ажиллалаа. Тус дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг 73 аж ахуй нэгж, байгууллагын 73 нягтлан бодогч хүрэлцэн ирлээ. Баянзүрх нэгдсэн эмнэлэгийн хамт олны хүсэлтээр



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 сарын 07-ны өдрийн А/177, А/433-р тушаал даатгуулагчдад эмнэлэгийн хуудас олгох журмыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, ЭМЯ-ны сайд, ХНХЯ-ны сайдын 2023 оны 12 сарын 15-ны өдрийн А/441, А/192 дугаарт хамтарсан тушаалыг танилцуулж, хэрэгжүүлж ажиллах, эрүүл мэндийн төвийн эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх цаашид үйлчлүүлэгчийн



диспансерийн хяналтыг сайжруулах, эрүүл мэндийн магадлалын зөвлөлд илгээж эмчилгээ, оношилгооны дүгнэлтийг стандартын дагуу гүйцэтгэхэд чанарын ахиц гаргах зорилгоор 2024.01.24, 2024.01.26-ны өдрүүдэд магадлагч эмч Я.Баяржавхлан, Нийгмийн даатгалын багц хуулийн талаарх ерөнхий ойлголтыг Тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг нар өгч, сонирхсон асуултанд хариулт өглөө. Сургалтанд БЗД-ийн Эрүүл мэндийн төв, БЗД-Өрхийн эрүүл

мэндийн нийт 46 төвийн 68 эмч, сувилагч нар оролцлоо.

Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан тус дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгуулагуудад 2024.02.22, 2024.02.23-ны өдрүүдэд орлого шимтгэлийн тасгийн байцаагч Б.Сауле, Н.Сайнбаяр, Мэдээллийн технологийн ажилтан Г.Энхбаяр, Сургалтын мэргэжилтэн Д.Ангараг нар дүүргийн нийт ажил олгогч болон нягтлан бодогч нарт зориулсан сургалт мэдээллийн цагийг өглөө, өдөр гэсэн 2 ээлжээр нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж шинэ системд нэвтрэн орох, тайлан бэлтгэх, илгээх зэрэг асуудлаар зөвлөн туслаж ажиллалаа. Сургалтанд нийт 120 аж ахуй нэгж байгууллагын 120 нягтлан бодогч оролцлоо.




тус дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгуулагуудад 2024.02.22, 2024.02.23-ны өдрүүдэд орлого шимтгэлийн тасгийн байцаагч Б.Сауле, Н.Сайнбаяр, Мэдээллийн технологийн ажилтан Г.Энхбаяр, Сургалтын мэргэжилтэн Д.Ангараг нар дүүргийн нийт ажил олгогч болон нягтлан бодогч нарт зориулсан сургалт мэдээллийн цагийг өглөө, өдөр гэсэн 2 ээлжээр нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж шинэ системд нэвтрэн орох, тайлан бэлтгэх, илгээх зэрэг асуудлаар зөвлөн туслаж ажиллалаа. Сургалтанд нийт 120 аж ахуй нэгж байгууллагын 120 нягтлан бодогч оролцлоо.



Шинжлэх ухаан технологийн хүрээлэнгийн ажилтан албан хаагч нарын хүсэлтээр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн талаарх сургалтыг 2024.03.11-ний өдөр тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг, Орлого шимтгэлийн байцаагч Н.Сайнбаяр, Алтанзагас нар орлоо. Сургалтанд нийт 49 албан хаагч оролцлоо.



Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт болон тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн талаарх сургалтыг 2024.04.19-ний өдөр 09 цагт Хилийн цэргийн 0228 дугаар анги, 11 цагт Глобаль сангийн дэмжлэгтэй дох, сүрьеэгийн төслийн ажилтан албан



хаагч нарт тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг амжилттай зохион байгуулж ажиллалаа. Сургалтанд нийт 95 ажилтан албан хаагч оролцлоо.



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажилтан, албан хаагч нарт 2024.05.08-нд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт болон тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн талаарх сургалтыг тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг, тэтгэмжийн байцаагч М.Шинэжил, Орлого шимтгэлийн байцаагч С.Ундрал нар хийж албан хаагчдын асуултанд хариулж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлт, хэрэгжилтийн талаарх танилцуулах уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд УИХ-ын гишүүн, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, НДЕГ-ын Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг нар хүрэлцэн ирж мэдээлэл өглөө.



Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлт болон орлого шимтгэлийн талаарх сургалтыг тэтгэврийн хяналтын байцаагч Д.Ангараг, Орлого шимтгэлийн байцаагч Б.Сауле, Хяналтын шалгалт, дотоод аудитын байцаагч Э.Нямдорж нар хийж албан хаагчдын асуултанд хариулж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа



БЗД-ийн ЗДТГазар, Санхүү төрийн сангийн хэлтэс болон Төсвийн болон орон нутгийн байгууллагуудын нягтлан бодогчид нар оролцлоо.

Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулж хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ зөвлөгөө мэдээллээр хангах зорилгоор Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг томоохон зах, худалдааны төвүүд болох Баялаг ундраа худалдааны төв, Нарантуул ОУХ-ны төв, Дүнжингарав худалдааны төв, Шөнийн зах, Сандэй плаза, Түмэн молл, Амгалан зах, Офицер зах, Баянзүрх худалдааны төвд явуулын үйлчилгээ зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.



Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг 2024 он 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбоотойгоор 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн тус газрын олон даатгуулагчтай томоохон ажил олгогчид болох Амгалан дулааны станц, стимо ХХК, Скайхайпермаркет ХХК, СЭМҮТ, Рехамед эмнэлэг, Петростар групп,



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Ус сувгийн удирдах газар, төв цэвэрлэх, гэх мэт ажил олгогчдод очиж сургалт хийн мэдээлэл өгч ажиллалаа.

Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан дүүргийн нийт ажил олгогчдод шинэ системд нэвтрэн орох, тайлан бэлтгэх илгээх зэрэг асуудлаар 8 удаагийн сургалтаар 400 гаран нягтлан бодогчдод танхимын сургалтаар зөвлөн тусалж ажиллалаа. БЗД-ийн ХХҮ газартай хамтран “Хөдөлмөр эрхлэлт” 2024 өдөрлөгт Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх аяны хүрээнд хамтран зохион байгуулсан.

2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр төсөвт байгууллагын 100 нягтлан бодогчдын сургалтыг Дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулж нийгмийн даатгалын шинэчилсэн хууль болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан илгээхтэй холбоотой сургалтыг хийлээ. Мөн их Отгонтэнгэр, Батлан хамгаалах их сургуулийн оюутнуудад нийгмийн даатгалын ач холбогдлын талаар сургалт хийсэн. Тус хэлтэст бүртгэлтэй ажил олгогчдын цахим группт мэдээлэл, зөвлөгөөнийг өгөн ажиллаж байна. Тус дүүрэгт байршилтай томоохон худалдааны төвүүд болох Сандэй, Дүнжингарав, Ханталст, Баялаг Ундраа, Шөнийн захуудаар хуваарийн дагуу ажиллан иргэдэд нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлын талаар мэдээлэл өгөн ажиллаж, сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэн ажиллалаа.



Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн мэдээллүүдийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.



Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйжээр хийсэн шимтгэлийн тайлан илгээх, даатгуулагчийн төрөл, шимтгэл ногдуулах орлого сэдвээр НДЕГ-ын ХШГ-ын дарга С.Лхагвадоржтой хамт мэдээл өгч, холбогдох асуултанд хариулж ажиллалаа.

Нийгмийн даатгалын системийн программ хангамжийн шинэчлэл хийгдэж байгаатай холбогдуулан тус газарт бүртгэлтэй ажил олгогч, нягтлан бодогчдод зориулсан сургалтыг шат дараалан хийж, мэдээллийг өгөн ажиллалаа.

Ажил олгогчийн нягтлан бодогчдод “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчилсэн найруулга, хууль тогтоомжид орсон өөрчлөлтүүд, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд анхаарах асуудлууд, нэмэгдсэн болон нэршил өөрчлөгдсөн датгуулагчийн төрлийн кодын талаархи мэдээллийг өгөн ажилласан.



Мөн олон нийтийн цахим хэрэгсэл болон баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст тайлан өгдөг аж ахуйн нэгж байгууллагын цахим группт мэдээллийг өгөн ажиллаж байна.



Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах

Тайлант хугацаанд даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай нийцсэн байна. Даатгуулагчийн регистрийн дугаар улсын бүртгэлийн мэдээллийн сантай зөрсөн зөрчил гараагүй байна.

Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.

- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.
- Даатгуулагчийн төрлийг буруу тайлагнасанг ажил олгогчтой залруулан ажиллаж, тайлангаа шалгаж илгээх талаар зөвлөгөө мэдээлэл өгөн ажиллаж байна.
- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.
- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.

Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэсэнг шлаган, шүүж залруулан даатгуулагчидтай холбогдон өргөдлийг аван залруулан ажиллаж байна.

- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг зөв хүлээн авсан байна.
- Даатгуулагчийн төрлийг буруу тайлагнасанг шалган засварлан ажиллаж байна.
- Даатгуулагчийн улсын кодыг зөв хүлээн авсан байна.

Гэрээг буруу байгуулснаас тухайн сар дээр ногдуулалт 2 орсон, ХХТАО-г буруу оруулан гэрээ байгуулснаас кредит үлдэгдэл үүсгэсэн мэдээллийг шүүн, залруулж ажиллаж байна.

Нийт 70-н ажилтан албан хаагчийн программын эрхэд тохиргоо хийж шинээр нэвтэрч буй Core системийн нэвтрэх эрх, ажиллах программын эрхийг тохируулан ажилласан. Мөн ажлаас гарсан, орсон албан хаагчдын шинэ, хуучин программуудын эрхийг хаах нээх ажлыг хариуцан ажиллаж байна. Нийт 15000 ажил олгогчийг орлого шимтгэлийн 10 байцаагчид хуваарилах ажлыг 2024 оны 03 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Нийт 12 албан хаагчийн хэрэглээний компьютерийн программ хангамжийг шинэчлэн форматлаж ашиглалтад орууллаа. МТТ-өөс шинээр нэвтэрч буй программ хангамжийн тохиргоо хийх даалгавар, үйл ажиллагааны чиглэлийг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Нийт 3 удаагийн цахим сургалтад хамрагдсан, 4 удаагийн тохиргоо хийх үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажилласан.

-203 тоот өрөөний дотоод сүлжээ 8 удаа доголдож засвар үйлчилгээг тухай бүрт хийж ажилласан

-Дээд газраас ирүүлсэн 32 ширхэг хэрэглээний компьютерийг хүлээн авч бүртгэлжүүлэн 31 албан хаагчид буюу байгууллагын хэмжээнд 50%-д нь компьютерийг нь шинэчлэн ашиглалтанд оруулсан

-Нэг цэгийн үйлчилгээний төвийн 15 компьютероос 3 ширхэг нь тог цахилгааны хэлбэлзэл, бусад 2 компьютер бусад шалтгаанаар тэжээлийн блок зэрэг нь шатсаныг оношлон засварт өгч ажилласан байна.

-301 тоот өрөөнд нэг байцаагчийн дотоод сүлжээг шинээр холболт хийж ажиллуулсан. Хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг 100 хувь авсан.

Нийт 70 ажилтан албан хаагчийн программын эрхэд тохиргоо хийж шинээр нэвтэрч буй Core системийн нэвтрэх эрх, ажиллах программын эрхийг тохируулан ажилласан.

Мөн ажлаас гарсан, орсон албан хаагчдын шинэ, хуучин программуудын эрхийг хаах нээх ажлыг хариуцан ажиллаж байна. Нийт 15000 ажил олгогчийг орлого шимтгэлийн 10 байцаагчид хуваарилах ажлыг 2024 оны 03 сарын 20-25 хооронд хийж гүйцэтгэв.

Нийт 12 албан хаагчийн хэрэглээний компьютерын программ хангамжийг шинэчлэн форматлаж ашиглалтад орууллаа.

МТТ-өөс шинээр нэвтэрч буй программ хангамжийн тохиргоо хийх даалгавар, үйл ажиллагааны чиглэлийг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Нийт 3 удаагийн цахим



сургалтад хамрагдсан, 4 удаагийн тохиргоо хийх үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, системийн шинээр нэмэгдсэн дэд цэсүүдийг 3 удаагийн заавар, зөвлөмжийг холбогдох ажилтнуудад өгч ажилласан.

Колл про үйлчилгээний дуудлага зохицуулах үйлчилгээний тохиргоо, холболт зэргийг нийт 3 удаа шинэчлэн хийж, тус компаний менежер Н.Урангоотой хамтран дуудлагын сүлжээнд бүрэн техникийн үзлэгийг хийж, тайлан гаргалттай холбоотой сургалтад хамрагдсан.

Нийт ирсэн 20975 дуудлагын ярианы бичлэгийг 7 хоногоор нөөцлөн хадгалах шаардлагатай тохиолдолд тухайн мэдээллийн сангаас тодруулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Нийт ажилчдын техникийн сайжруулалт ашиглалтыг нэмэгдүүлж 56 компьютер, 15 принтер зэргийг солих сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт байцаагч ажилтнуудад Програм хангамжийг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар 2 удаагийн сургалтын зохион байгуулж, програмын эрх олголтын бүртгэл, хяналтын карт хөтлөн ажиллаж байна.

БУСАД ХИЙГДСЭН АЖИЛ

“Улаанбаатар Марафон-2024” олон улсын гүйлтэд нэгдэцгээе аяны хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооноос Шилжин явах цомыг хүлээн авч, 23-ны өдөр Газар зохион байгуулалтын алба 1-д хүлээлгэн өгсөн.



“Улаанбаатар Марафон-2024 нэгдэцгээе” цом аялах аяны хүрээнд тус байгуулж ажиллалаа.

газар дараах ажлыг зохион

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хамтдаа хуваалцъя” аяныг байгууллагадаа өрнүүлж, хандив тусламжийг дүүргийн түр хамгаалах байранд амьдарч байгаа хүмүүст

хүргэж ажилласан.





Эерэг хандлага, Эрүүл нийгэм аяны хүрээнд
Ажлын байрны дасгалын уралдаанд нэгдэж
оролцсон.




Нийгмийн даатгалын хамт олны “Эрүүл монгол хүн-Эко аялал” өдөрлөгийг Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Баян давааны “Рашаан толгой”-д зохион байгуулж ажилласан.

- Өдөрлөгийн хүрээнд “Рашаан толгой”-н өмнөх уулсын ойн зах, рашааны сав газраар 5 км алхалт хийсэн.
- Рашаан толгойн ойр орчны хог хаягдлыг цэвэрлэсэн.
- Нийт албан хаагчдын дунд авхаалж самбаа шаардсан хөгжөөнт тэмцээн уралдаан зохион байгуулж ажиллалаа.



2024 оны 04 дүгээр сард байгууллагын эргэн тойронд 50 м талбайд их цэвэрлэгээ хийлээ. Мөн байгууллагын гадна дотно цонх, шал талбайг угааж, цэвэрлэсэн.






Хаврын их цэвэрлэгээний нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус газар 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр 21 дүгээр хороо, Бага дарь эх 1, 5, 6 хэсэг, Бага дарь эх Шинэ буудлаас Ганцын задгай 12 хэсэг, Дарь эх хороо холбосон шинэ зам, Уулын шинэ зам, дарь эхийн замын 2 тал бүхий заагдсан талбайд их цэвэрлэгээ хийлээ.



Хорооны Засаг дарга Н.Эрдэнэзаяатай /99094794/ холбогдон хорооны хэсгийн ахлагч болон хог цэвэрлэгээ хариуцсан ажилтны хяналтан дор цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ.



“Мод тарих Үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Баянзүрх дүүргийн Засаг даргын А/320 дугаар захирамжийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын өдрийн Баянзүрх дүүргийн 33 дугаар хороо, Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, Баянзүрх дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Баянзүрх нэг зүрх төв” хамтран 33 дугаар хорооны айл өрх болон цэцэрлэгт

23-ны



хүрээлэнд мод тарьсан. Тус газар нийт хайлаас мод-50 ш, агч мод-50 ширхэгийг нийт 10-н өрхөд тарьж суулган хүлээлгэж өглөө.



“Улаанбаатар Марафон-2024” олон улсын гүйлтэд нэгдэцгээе аяны хүрээнд тус газрын нийт албан хаагчид Эрүүл мэндийн гүйлт 5 км төрөлд “ubmarathon.hipay.mn”-д бүртгүүлэн, номер дугаараа авч, 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан марафонд амжилттай оролцлоо.





Баянзүрх дүүрийн түр хамгаалах байранд орон гэргүй амьдарч байгаа хүүхэд болон эмэгтэйчүүдэд хандив үзүүлэх “Хамтдаа хуваалцъя” аянг газрын албан хаагчдын дунд өрнүүлж цугларсан хандивын зүйлсийг хүргэн өгсөн. Мөн БЗД-ийн ЗДТамгын газраас зохион байгуулсан “Хайраар тусалъя аян”-д нэгдэж бичгийн хэрэглэл, хүүхдийн форм, гутал зэрэг цугларсан хандивыг тамгын газрын хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч ажиллалаа.



..... дүүргийн түр хамгаалах байранд орон гэргүй амьдарч байгаа хүүхэд эмэгтэйчүүдэд өчүүхэн ч гэсэн сэтгэлийн хандив үзүүлэн, “Хамтдаа хуваалцъя” аянд нэгдсэн хамт олондоо баярлалаа.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ШУУРХАЙ ШТАБЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН



Гамшгаас хамгаалах хүн ам нийгмийн хамгааллын улсын алба, төв штабын сургалтаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Алтанцэцэг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 05 цаг 08 минутанд дуудлага мэдээллийг Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэргэжлийн ангийн дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын дарга Ш.Ариунтуяад өгсөний дагуу тус дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга Г.Болорсүх, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтсийн дарга Ц.Үүрцайх нарт дуудлага мэдээллийг шуурхай хүргэж ажилласан.





Онцгой байдлын хэлтсийн 4 албан хаагч нийт 40 хүний бүрэлдэхүүнтэй баг гамшигаас хамгаалах мэргэжлийн ангийн ажлын хувцас, багаж хэрэгсэлтэй Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын 401 тоодот дараагийн дуудлага, мэдээллийг хүлээн авахад бэлэн байдалтай цугларсан.



2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 09 цаг 30 минутанд гамшигаас хамгаалах дохио дугаарч тус барилгат байсан албан хаагчид Баянзүрх дүүргийн 55р сургуулийн хашааны цуглах талбайд гарч бүртгэл хийхэд 74 албан хаагчдаас 66 албан хаагч цугларч Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтсийн ахмад Б.Үүрийнтуяа мэрэгжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан.



ХҮН АМ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АЛБА
ГАМШГИЙН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛИЛТ





Монгол Улсын Шадар сайдын баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газраас Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албанд / БЭД Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс,

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс/ гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг зохион байгуулан ажилласан.



Сургуулилтад нийт 153 ажилтан оролцож Газар хөдлөлтийн цагийн байдал дээр даалгавруудыг биелүүлэх замаар хариу арга хэмжээний төлөвлөлт болон ажиллагааны, нөөц хангамжийн тооцооллуудыг багаараа хамтран хийж гамшгийн үеийн бэлэн байдалд суралцлаа.



Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд

Зэвсэгт хүчний Жанжин штаб,
Төрлийн цэргийн командлалууд,
Барилга-инженерийн цэргийн
удирдах газар, нэгтгэл анги,
салбаруудад Нийгмийн даатгалын
тухай хууль, цэргийн алба хаагчийн
тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль,
нийгмийн даатгалын тайлантай
холбоотой асуудлын талаар мэдээ
мэдээлэл хүргэн ажиллалаа.



Сургалтыг тэтгэврийн
хяналтын байцаагч
Д.Ангараг Хамралт
орлогын байцаагч
Д.Сайнбаяр Сургалт
сурталчилгааны
мэргэжилтэн
С.Мөнхзаяа нар
мэдээлэл хүргэж

Сургалтад нийт 300
ажилтан алба хаагч
оролцож сонирхсон
асуултад хариулт өгч
ажиллалаа.

АЛБА ХААГЧДЫН МЭДЭЭЛЛИЙН
ЦАГААР БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗРЫН НЭГДҮГЭЭР
ХЭЛТЭС-ээс “Телеграмм платформ
ашиглан үйлдэгдэж байгаа залилан
мэхлэх гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх сэдэв”-т сургалтад Нийт алба
хаагчид хамрагдлаа.





ДОХ-ын асуудалд олон нийтийн анхаарал хандуулах дэлхийн өдрийн хүрээнд БЗДЭМТ-с эрүүл мэндийн мэдлэг олгох сургалтад идэвхтэй сайн оролцож сайн дурын шинжилгээнд 49 ажилтан хамрагдан бүгд эрүүл гэсэн хариу гарсан.





БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Амьдах урлаг Yoga бясалгалын төвөөс Ажлын байрны стрессээс хэрхэн ангид байх, Yoga бясалгалын ач тусын талаар байцаагч ажилтануудад сургалт орж идэвхитэй хамрагдлаа.



ТАЙЛАНГ ХЯНАСАН: ДАРГА

Ш.АРИУНТУЯА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ӨНӨРБУЯН

